



# ЦЭЦЭРЛЭГ Мандал уулын Өлзийт уулын хошуунд сургууль байгуулагдсан түүхээс /1920-1931 он/



АЕГ-ЫН Сургалт, судалгааны газрын  
эрдэм шинжилгээний ажилтан Г.Сэр-Од

Мөнхүү хошуу тамгын газраас ч Ардын засгийн газраас дэвшүүлэн тавьж буй зорилтыг чандлан сахиж, “... Засгийн газраас тогтоон тушаасан ёсоор ...өөр өөрийн сум отгоос төлөөний түшмэл, сургуулийн хөвгүүдийг сонгон томилж, гурван сарын хүнс, ирэхийн хэрэглэл, суух гэр, түлш зэргийг нийлүүлэн өгч энэ арван хоёр сарын найманд манай тамгын газар (Цэцэрлэг Мандалын аймгийн Өлзийт уулын хошууны тамгын газар. Г.С) хүрэлцэн ирүүлж, суулгасугай. Ийм тушаасан хойно үхээнц доройг томилж ор нэр болгон болзоог алгуурлах зэрэгт хүргүүлбээс огт үл болмой” хэмээх зэргээр магадлан гүйцэтгэж байв.

Ардын Засгийн газар, Дотоод яамнаас олон хошуудад байгуулагдан буй бага сургуулийн дүрэм хэмжээг тогтоон, МАХН-ын Төв Хорооноо илгээн, "...айлтгасан нь, олон бага сургуулийн дүрэм хэмжээг запруулан нэмж зохиосонявлыг хичээнгүйлэн нугалбар бичиж айлтгаад, Богд хаан гэгээнээр толилохыг гүйхын учир, сая манай сургуулийн дүрэмд хөдөөгийн олон газар байгуулах сургуулийн дүрмийг нэмэн бичиж хавсран нийлүүлж, төлөвлөсөн дүрэм хэмжээ бүгд хорин зургаан зүйлийг батлан тогтоому хэмээн Засгийн газраа явуулсанд ...тусгай хуудсаар сийрүүлэн бичиж зүй нь хичээнгүйлэн нугалбар бичиж айлтгаад, ...мөн сарын шинийн найманд хүлээн авсан уг нугалбарт улаан бийрээр цохсон Зарлиг мэдэв хэмээснийг хичээнгүйлэн дагаж байцааваас, үүний урьд манай Дотоод яамнаас энэ удаа...Сайн ноён хан аймгийн чуулганы дарга ... эдгээр есөн газар бага сургуулийн танхим нэжгээдийн үүсгэн байгуулахаар Засгийн газрын хуралд батлан тогтоосон..." байна. Энэ нь Өлзийт уулын хошуунд европ загварын сургууль боловсролын дэлгэрэх суурь дэвсгэр болсон байна.

Дотоод яамнаас эрхлэн гаргасан дүрэмд заасанчлан сурагчдын хоол хүнс, хэрэглэх зүйлийн талаар сонирхон үзвэл, "...Цэцэрлэг Мандал аймагт нээн байгуулах бага сургуулийн танхимд оруулах хэмжээт насны хөвгүүдийг Сайн ноёны зэрэг хорин хоёр хошуу, гурван шавьд нэжгээдээр зарлаж, уул сургуулийн хүүхдүүдэд тогтоолын ёсоор хэрэглүүлэх хэрэглэл зүйлийг нэгэн жилээр бодож нэг бүр дөчин жин махын хонь, цагаан гурил гурван мянга зургаан зуун жин, зузаан цай хорин дөрвийг хүүхэд ноогдсон газруудаас урьдаар гаргуулж цаг дараалан нийлүүлэх учрыг ялган салгаж, шийтгэн ..." өгсөн байх ажээ.

1924 оны 09 дүгээр сарын 12-ны өдөр хуралдсан Цэцэрлэг Мандалын аймгийн гучин дөрвөн хошуу, шавийн газраас дүрмийн ёсоор сонгогдон ирсэн төлөөлөгчид нийлж, анх удаа харьяат аймгийн их хурлыг нээн байгуулж эрхэлбээс зохих хэргүүдийг хэлэлцсэн нэгдүгээр хурлын тогтоолын 37 дугаар зүйлд: "...танхимиын хөвгүүдийн элдэв хэрэгсэхийг аль сайнаар бэлтгэж эрдэм соёлд гэгээрэхэд тустай болгохыг хэлэлцээд харьяат хурлын гишүүдээс комисс томилон сургагч нарын хамт тэрхүү хөвгүүдийн орон сууц, хэрэглэхүүнийг байцаан үзүүлж, дутагдах хэрэглэлийг зүйлчлэн бичиж ирсэн..." -ээс үзэхүл тэр үед сургуулийн танхим хэдийнэ нээгдсэн байх бөгөөд холбогдох зардлыг хошууны сангаас бус аймгийн яамнаас даруйхнаа гаргахаар тогтжээ.

1925 оны 03 дугаар сарын 13-ны өдөр Цэцэрлэг Мандалын аймгийн Цаг зуурын хурлыг нээж элдэв олон зүйлийн хэрэг хэлэлцсэн зургаадугаар хурлаар харьяат аймгийн олон чухал асуудал хэлэлцэхдээ "...бага сургуулийн танхимын сурагч Чойжилоос харьяа сургуулийн багачуудын өмсөх хувцас өнгө адилыг цөм нэгэн аяс болгож хэрэглэвээс болох эсэхийг тогтоому хэмээснийг хэлэлцээд тийнхүү нэгэн аяс хувцас хэрэглэх нь маш зүйтэй болох тул аль яс янз зохилдохыг аймгийн яамнаас эрхлэн гүйцэтгэхээр хэлэлцэн тогтсон" байна.

Мөн ядуу ардын хүүхэд багачуулыг сургах асуудал дээр ч ихээхэн анхаарч байсан байна. Тухайлбал, 1924 оны 12 дугаар сарын 08-ны өдөр Засгийн газраас Монгол Ардын Намын төв Хорооноо илгээсэн 1170 тоот албан бичгийн агуулгаас харахад "...Монголын ядуу ардын хүүхэд багачуулыг тусгайлан улсын сангаас хэрэглэл зүйлийг олгож, сургуульд боловсруулах ..." чухал болохыг туйлаар дэмжиж байв.

МОНГОЛ УЛСЫН АРХИВЫН ЕРӨНХИЙ ГАЗАР

АРХИВЫН ЕРӨНХИЙ  
ГАЗАР





# АНХААРАЛ ХАНДУУЛСАН ТАНД БАЯРЛАЛАА

ЦАХИМ  
ХУУДАС



[www.  
ARCHIVES.GOV.mn](http://www.ARCHIVES.GOV.mn)

SOCIAL  
NETWORK

[www.facebook.com/](https://www.facebook.com/)  
Архивын ерөнхий  
газар

ЛАВЛАХ  
УТАС  
**1800-1205**

ЦАХИМ  
ШУУДАН



Аливаа улс орны хөгжлийн нүүр царайг тухайн ард түмнийх нь соёл, боловсролын түвшингээр тодорхойлогдож байдаг.

Төр ёс тогтсон цагаас эхлэн гэрийн сургалтын арга зүйд тулгуурласан төрийн сургуулийн эх үндэс тавигджээ. Аливаа сургалт нь ордны, албаны, дагалдуулан гэсэн гэсэн хэд хэдэн төрлөөр хөгжиж иржээ.

XVIII зуун буюу Манж Чин улсын үеийн монголын сургууль боловсролын талаар Галдан туслагч “Эрдэнийн эрхи” сурвалждаа: “32 дугаар он /энэ нь Манж Чин улсын Тэнгэрийн тэтгэсэн (1711.1736-1795 он)-ы төр барьсан 32 дахь жил болох 1767 он.Г.С/-д өөлд, мянгадаас хорин хүүхэд гаргаж манж, монгол бичиг сургахаар айлтгаж тогтжээ” хэмээсний гадна мөн энэ тухай “...Дөрвөдийн 8, Торгуудын 2, Алтайн Урианхайн 4, Өөлдийн 2, Захчины 2 нийт хорин хүүхэд...” сурч байсныг Ховдын засгийн хэргийн бүгд цэсийн оршилд дэлгэрэнгүй тэмдэглэжээ.

Манж Чин улсын үеийн төрийн сургуулийг 1д: монгол бичгийн сургууль, 2т: манж бичгийн сургууль, 3т: манж хятад бичгийн сургууль, 4т: монгол манж бичгийн сургууль, 5д: монгол хятад бичгийн сургууль, 6д монгол манж хятад бичгийн сургууль хэмээн тус тус ангилжээ.

Манж Чин улсын Бадаргуулт төр хаан (1871.1875-1908 он)-ны сууринд суусан 1875 оноос засаг захиргааны албан харилцаа улам нэмэгдсний хирээр манж бичгээс гадна хятад бичиг хэрэглэх болж үүгээр хятад хэл бичиг мэддэг хүний хэрэгцээ нэмэгдсэний тулд 1898 онд Хүрээн дэх Манж сайдын газар “**манж, хятад бичгийн сургууль**” байгуулж, түүндээ Халхын Түшээт хан, Сэцэн хан аймгууд болон Их шавийн нутгаас бичиг үсэгт сонирхолтой хүүхдүүдийг авч сургаж эхэлсэн байна. 1908 оноос манж, хятад бичгийн сургуулийг “**Сурган тэжээх сургууль**” нэртэйгээр шинэчлэн манж, монгол бичигт сургах сургууль болгосон байна. Энэ сургуулийн гол сурах бичиг нь “Хааны бичсэн дөрвөн зүйлийн үсэг хавсаргасан толь” хэмээх бичиг байв.

1910-аад оны дунд үест Монгол улсын иргэний боловсролыг хөгжүүлэх олон арга хэмжээ авсны нэг нь 1911 онд анхны “иргэн”-ий шинжтэй, европ загварын сургуулийг 1912 оны 3 дугаар сарын 24-ний өдөр Халхын дөрвөн аймаг, шавь таван газраас зарлан ирүүлсэн 47 хүүхдийн бүрэлдэхүүнтэйгээр Гадаад хэргийг бүгд эрхлэн шийтгэгч яамны дэргэд нээжээ.

Түүнчлэн “Зарлигаар тогтоосон Монгол улсын хууль зүйлийн бичиг”-ийн “Сургуулийн танхим байгуулж, бага хөвгүүдийг эрдэм сургахуй” хэмээх бүлэгт зааснаар “Нийслэл хүрээ ба олон хошуу, шавь газар бага, дунд, дээд зэргийн сургуулийн танхим байгуулж, бага сургуулиас үүсгэн зүйл бүрийн эрдэм чадлыг зэрэг дэс буй” хэмээн хуульчилснаар шаталсан тогтолцоогоор хүмүүнд эрдэм олгох европ загварын сургууль боловсролын эхлэл тавигджээ. Ийнхүү европ загварын сургууль боловсролын тогтолцоог хөгжүүлэх санаачлагыг Буриадын эрдэмтэн Ж.Цэвээн гаргаж байв.

Тус сургуульд 1912 онд Үйзэн вангийн хошуунаас 1, 1913 онд Илдэн бэйлийн хошуунаас С.Довчин, 1915 онд Шарав нарын хүүхдүүд ирж суралцаж байв. Ийнхүү Хүрээнд иргэний сургуулийн танхим байгуулагдаж эхэлснээр 1912-1913 оны хооронд 60 гаруй бага сургуулийн танхим байгуулагдсанаас 49 нь Сайн ноён хан аймгийн олон хошуудын нутагт байгуулагджээ. Эдгээр хошуудын сургуулиудаас Илдэн бэйлийн хошуунд Чойжав занги, Сайн ноёны хошуунд Дамдин мээрэн, Үйзэн вангийн хошуунд С.Жигмэддорж нарын багш нар багшилж байв. Түүнчлэн иргэний сургуулиас гадна томоохон хүрээ хийдүүдийн дэргэд олон тооны шашны сургуулиуд шашны боловсролыг түгээж байв.

1914 онд Гадаад хэргийг бүгд эрхлэн шийтгэгч яамны дэргэд Эрдэнэ дайчин чин ван М.Ханддоржийн санаачлага, зүтгэлээр анхны сургуулийг байгуулж, арав гаруй хөвгүүдийг орос, монгол хэл бичиг, ба зурхайн сургаад Эрхүү, Хиагт газрын сургуулиудад үргэлжлүүлэн сургаж байжээ. Мөн тус яамны дэргэд монгол хүүхдийг сургахад зохиулан орос сургууль байгуулахад Сайн ноён аймгаас 20 хүүхэд суралцсан байна.

蒙古文書

طعنه شدند و بسته باید این را در میان اینها مذکور نمایند.

અનુભૂતિ

**Бага сургуулийн танхимын дүрэм (18 зүйлтэй).  
Олноо өргөгдсөний тавдугаар он зуны сүүл сарын  
шинийн найман. 1915.07.20**

**Бага сургуулийн танхимын дүрэм (4 бүлэг, 29 зүйлтэй).  
Олноо өргөгдсөний тавдугаар он зуны сүүл сарын  
шинийн найман. 1915.07.20**

مختفیان تم (استهان) و پایه‌ها می‌توانند تغییراتی را در این مکانات ایجاد کنند.

卷之三

«میشنهن» یعنی محدثین میں عصیانی و نکاحی را تایید نمودهند، یعنی (۲)

وَجَاهَتْهُمْ بِالْأَنْقَادِ مُدْعِيًّا بِمُكْثَرٍ مِنْ أَعْمَالٍ كُفْرٍ

میخواهند که این را می‌دانند و این را می‌دانند و این را می‌دانند

## АРХИВЫН ЕРӨНХИЙ

### ГАЗАР

### Цэцэрлэг Мандал уулын Өлзийт уулын хошуунд сургууль байгуулагдсан түүхээс /1921-1930 он/

1921 онд Ардын хувьсгал ялж, Ардын засгийн газраас баримталсан нэгэн зорилт нь ард иргэдийг гэгээрэл, боловсролын байдалд эрс өөрчлөлт гаргах нь зайлшгүй тулгаран гарсан байна.

Ардын Засгийн газар 1921 оны 08 дугаар сарын 14-ний өдрийн хуралдаанаараа ардын хөвгүүд, охидыг бичиг үсэгт сургаж, олон түмний хэрэгт туслуулах нь үнэхээр сайн хэрэг тул Засгийн газраас өөрөө эрхэлж, цаашид нарийн чанд дүрэм хэмжээ зохиож ажиллахаар дараалан арга хэмжээ авч хэрэгжүүлжээ.

Улмаар Ардын засгийн газраас 1921 оны 08 дугаар сарын 25-ны өдрийн хуралдааны нэгддүгээр зүйлд “Бага сургуулийн танхим”-ыг Нийслэл хүрээ, Халх, Дөрвөдийн аймаг, шавь зэрэг газар байгуулж, 8-13 насны хүүхдийг үндэсний бичиг үсэгт сурган боловсруулахаар тогтоож, сургуулийн зохион байгуулалт, хичээлийн программ зэргийг тодорхой заасан 26 зүйл бүхий дүрмийг баталжээ.

## АРХИВЫН ЕРӨНХИЙ ГАЗАР

Олноо өргөгдсөний 11 оны 10 дугаар сарын 3 буюу аргын улиралын 1921 оны 11 дүгээр сарын 02-ны өдөр Нийслэл Хүрээний бага сургуулийн танхим нэгийг үүсгэн байгуулж, Дотоод хэргийг бүгд захиран шийтгэгч яамнаа эрхлэн хариуцуулж, мөн 1922 оны 03 дугаар сараас эхлэн Халхын дөрвөн аймаг зэрэг газар бага сургуулийн танхим тус бүр нэгийг байгуулсан бол 1924 он хүртэл бага сургуулийн танхим 16 нээн байгуулж, нас тэнцэх хөвгүүд, охид 400 илүү хүүхдийг суулгаж 20 буюу 25 хүүхдийг нэг анги болгон, анги бүрт нэг багшийг сонгон суулгасан ба мөн танхимиын даргыг багш нарын нэгэнд хавсаргаж, монгол бичиг унших, бичих, тоо бодох гурван зүйлийг урьтал болгон сургаж бүхийгээс гадна дүрмийн ёсоор заан сургах зүйлийг жил дараалан дэвшүүлэн сургаж улмаар дунд сургуульд орохыг бэлтгэн буй ажээ.

1920-иод оны эхээр улсаас байгуулсан аймаг, хошууны бага сургуулиудад сургуулийн танхим, орон байр, ус түлш, хоол хүнс зэрэг хэрэглэлийг харьят орон нутгийн захиргаадаас зүй ёсоор гаргуулж, гагцхүү багш нарын цалинг улсын сангаас олгож байжээ.

Дотоод яамнаас Цэцэрлэг Мандал аймгийн яаманд ирүүлсэн нэгэн бичигт: "...олон хөвгүүд, охидын сургуулийн танхим байгуулахыг хэлэлцээд энэхүү сургуулийн танхим нээж олон хөвгүүд, охидыг насан багад элдэв зүйлийн бичиг заан сургаж, ... (эхэд нэг үг балархай байна. Г.С) судлуулан олон түиний хэрэгт туслуулах нь үнэхээрийн сайн хэрэг тул эл танхим байгуулан хуралдуулж, сургах хэргийг Засгийн газраас эрхэлж, нарийн чанд дүрэм хэмжээ тогтоож, улсын хуралд дахин үзүүлэн тогтоолгохоор хэлэлцэн тогтжээ" хэмээн учир зүйг өгүүлэхийн сацуу ач холбогдлыг тодруулжээ. Мөн цааш нь "...бага, дунд сургуулийн танхимыг дараа дараагаар нээн...буулгасан Зарлигийг хичээнгүйлэн дагаж, одоо даруй тушаалын газар ирж эл хэргийг уул тогтоосон дүрмийн ёсоор нээн журамлан зүтгэвээс зохимой. ... Урьд Засгийн газраас зааж зарлан бэлтгүүлсэн сургуульд оруулбаас зохих Хүрээнээ бүхий хөвгүүд, охидынаймаг, хошуу, нэр насыг тодорхойлсон цэс үйлдэж нэн хурданаа манай Дотоод яамнаа мэдүүлэн хүргэж ирүүлээд тоог мэдэж, хэдэн сургууль байгуулбаас зохихыг тогтоож сургагч багш нар заан томилж өдөр цагийг тогтоон зарлаж хуралдуулан бага сургуулийг нээн явуулахад бэлтгэсүгэй..." хэмээн дурдсанаас үзэхүл, сургуулийн танхим байгуулах үйл ажиллагаа нэлээд эрт эхэлсэн нь тодорхой байна.